

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар  
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/26/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
(Дорноговь аймаг, Сайншанд сум)  
2018 он

Тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
Утас:99092469	Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежер:	Ц.Лүндэгмаа
Утас:99026829	Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn
Аудитор:	Н.Мягмарсүрэн
Утас: 96036499	Цахим хаяг sain.audit5851@gmail.com

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
3.1	(Аудитын чиглэл).....	
3.1.1	Илрүүлэлт:.....	
3.1.2	Эрсдэл: .....	
3.1.3	Өгсөн зөвлөмж: .....	
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: .....	
3.2.1	Илрүүлэлт:.....	
3.2.2	Эрсдэл: .....	
3.2.3	Өгсөн зөвлөмж: .....	
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: .....	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	

1 Аудитын гэрчилгээ

  
**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншад сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗРЫН ДАРГА Д.СҮРЭН ТАНАА

2019-02-22 № 1-6/111  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.


**Зөрчилгүй санал дүгнэлт**

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.



Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын удирдлага Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Д.Сүрэн-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018.01.28-наас 2019.01.30-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018.02.18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Сайн- Аудит ХХК-ийн аудитор Н.Мягмарсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.02.18-ны өдрийн 71 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь Эко системийн даацад тохируулан тогтвортой хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр иргэн аж ахуйн нэгж байгууллагын хамтын ажиллагаа хүчин чармайлтыг өрнүүлэх замаар хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чиглэсэн байгаль орчныг хамгааллын бодлого боловсруулах хэрэгжүүлэх байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тус газрын эрхэм зорилго оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилго тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүний амьдрах, хөдөлмөрлөх, амрах байгаль орчны тааламжтай нөхцлийг бүрдүүлэх
- Аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлого боловсруулах, зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах.
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийн халдашгүй байдлыг хангах

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
- Усны тухай хууль
- Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
- Амьтны тухай хууль
- Байгаль ургамлын тухай хууль
- Ургамал хамгааллын тухай хууль
- Байгалийн нөөц ашиглалтын тухай хууль
- Хог хаягдлын тухай хууль
- Аялал жуулчлалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт орлого* -ын 1 хувиар сонгов.

*Нийт орлогыг* материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийдэгтэй .холбоотой юм.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2018 оны 417.798.1 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 4,177.98 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	658.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	1,286.10	
	Дүн	2	1,944.10	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Байгууллагын дарга Д.Сүрэнд төрийн албан хаагч нь ажлын зайлшгүй шалтгаанаар ээлжийн амралтыг биеэр эдлээгүй тохиолдолд албан тушаалын цалингийн 1,5 хувьтай тэнцэх хэмжээний урамшуулал олгох тухай Аймгийн засаг даргын шийдвэр гарсан байтал ээлжийн амралтыг бүтэн бодож олгосноор 1286,1 мянган төгрөгийг илүү тооцон олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх илүү олгосон амралтын олговрыг Д.Сүрэнгээр төлүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2.8.1.3 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

**2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой (2) хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 402.775.1

мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 409.167.5 мянган төгрөг буюу 97 хувьтай байгаа нь зарим зардлууд 29,3 сая төгрөгөөр хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

2018 оны тайлант хугацаанд нийт 3.5 сая төгрөгийг орлого төвлөрүүлэхээс 11.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 7.8 төгрөгийг давуулан биелүүлсэн байна.

## **2.10 Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.12 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Санхүүгийн тайлангийн аудит**

##### **Илрүүлэлт**

Ээлжийн амралтыг илүү тооцож олгосон нь “Үнэлгээ”, “Хэмжилт”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна. Энэ зөрчил нь төрийн албан хаагч нь ажлын зайлшгүй шалтгаанаар ээлжийн амралтыг биеэр эдлээгүй тохиолдолд албан тушаалын цалингийн 1,5 хувьтай тэнцэх хэмжээний нөхөн олгох гэсэн төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.9 дэх заалтыг зөрчсөн.

##### **Эрсдэл**

Ээлжийн амралтын нөхөн олговрыг хуулийн дагуу тооцож олгоогүйгээс ажилчдад илүү дутуу олгох

##### **Өгсөн зөвлөмж**

Төрийн албан хаагч нь ээлжийн амралтыг биеэр эдлээгүй тохиолдолд эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэн албан төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.9 дэх заалтыг мөрдөх

#### **3.2 Илрүүлэлт**

3.2.1 НДШ-ийг илүү тооцон суутгасан нь “Үнэлгээ”, “Хэмжилт”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдүүлэгтэй нийцэхгүй байна. Энэ зөрчил нь Тэтгэвэр тогтоолгосон ажилтны НДШимтгэлийг тооцохдоо даатгуулагчийн төрөл буруу сонгосноос даатгуулагч ажил олгогчийн төлөх НДШимтгэлийг илүү суутгаж тайлагнасан нь Ажил олгогч хөдөлмөрийн гэрээгээр эсвэл иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасны дагуу иргэнтэй байгуулсан гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч нь энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3,5 д зааснаас бусад төрлийн даатгалд заавал даатгуулна гэсэн заалтыг зөрчсөн.

### 3.2.2 Эрсдэл

Нийгмийн даатгалын тухай хуулийг мөрдлөг болгоогүйгээс НДШимтгэлийг илүү тооцох

### 3.2.3 Өгсөн зөвлөмж

Ажил олгогч хөдөлмөрийн гэрээгээр эсвэл иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасны дагуу иргэнтэй байгуулсан гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч нь энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3,5 д зааснаас бусад төрлийн даатгалд заавал даатгуулна гэсэн заалтыг мөрдөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019/05/01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,305,477.00</u></b>	<b><u>6,826,628.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	2,506,960.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	2,506,960.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	2,506,960.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	2,506,960.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,807,479.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,807,479.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	1,327,479.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	480,000.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	2,497,998.00	4,319,668.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	2,497,998.00	4,319,668.00
35410	Бичиг хэргийн материал	966,750.00	796,650.00
35420	Аж ахуйн материал	1,361,248.00	1,831,418.00
35440	Түлц, шатах тослох материал	170,000.00	1,691,600.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>62,083,314.68</u></b>	<b><u>144,263,459.13</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	62,083,314.68	144,263,459.13
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	62,083,314.68	53,415,459.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	11,691,240.00	9,935,093.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	-4,418,631.77	-900,000.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,625,720.00	69,625,720.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-56,095,478.29	-62,847,962.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	74,539,830.48	80,592,970.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	-57,023,890.03	-61,942,831.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,109,791.00	12,109,791.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,908,644.84	-7,044,624.92
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,618,230.00	25,968,230.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,054,851.87	-12,080,927.33

Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	00.00	90,848,000.00
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	90,848,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>66,388,791.68</u></b>	<b><u>151,090,087.13</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,056,000.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,056,000.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,056,000.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	48000.00	
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,008,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	528,000.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	480,000.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>65,332,791.68</u></b>	<b><u>151,090,087.13</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	65,332,791.68	151,090,087.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	117,277,647.48	208,125,647.48
51101	Өмч: - төрийн	117,277,647.48	208,125,647.48
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-52,241,152.47	-61,298,209.77
51210	Өмнөх үеийн үр дүн	-52,241,152.47	-52,241,152.47
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-9,057,057.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	296,296.67	4,262,649.42
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>66,388,791.68</u></b>	<b><u>151,090,087.13</u></b>

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>384,611,867.00</b>	<b>417,798,081.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>46,585,867.00</b>	<b>12,835,481.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	46,585,867.00	12,835,481.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	45,306,388.00	11,360,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,125,000.00	11,360,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,760,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,421,388.00	00.00
120009	Бусад орлого	1,279,479.00	1,475,481.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>338,026,000.00</b>	<b>404,962,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	338,026,000.00	402,775,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	338,026,000.00	402,775,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	2,187,500.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,187,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>392,202,084.77</b>	<b>425,254,333.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>392,202,084.77</b>	<b>425,254,333.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	364,086,930.67	398,425,713.70
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	131,004,570.00	143,630,419.00
210101	Үндсэн цалин	124,631,391.00	137,687,327.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,373,179.00	5,943,092.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	15,336,083.00	17,294,727.64
210201	Тэтгэврийн даатгал	9,978,791.00	10,798,120.00
210202	Тэтгэмжийн даатгал	955,312.00	1,501,593.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,340,515.00	1,120,496.00
210204	Ажилгүйдлийн даатгал	390,035.00	366,121.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,671,430.00	3,508,397.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,455,032.00	4,610,176.00
210301	Гэрэл, цахилгаан	577,764.00	716,716.00
210302	Түлш, халаалт	3,460,684.00	3,240,466.00
210303	Цэвэр, бохир ус	416,584.00	652,994.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,769,554.28	9,650,162.00
210401	Бичиг хэрэг	854,807.68	1,381,882.00
210402	Тээвэр, шатахуун	6,385,500.00	6,468,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,479,004.60	1,395,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	126,000.00	126,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	924,242.00	278,580.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	00.00	494,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	494,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,295,602.00	3,955,160.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	361,460.00	417,560.00
210602	Тавилга	330,000.00	00.00
210604	Урсгал засвар	14,604,142.00	3,537,600.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	1,482,100.00	1,478,500.00
210702	Дотоод албан томилолт	1,482,100.00	1,478,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	46,143,056.00	36,420,560.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,655,000.00	34,898,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	178,000.00	178,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	325,950.00	337,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	138,530.00	140,610.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	800,576.00	800,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	140,600,933.39	180,891,509.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	113,764,220.00	162,154,966.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	353,100.00	300,000.00

Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,483,613.39	18,436,543.06
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,115,154.10</b>	<b>26,828,619.36</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,800,000.00</b>	<b>00.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,800,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>23,315,154.10</b>	<b>26,828,619.36</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,315,154.10	26,828,619.36
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-7,590,217.77</b>	<b>-7,456,252.06</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>1,600,805.24</b>
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	1,600,805.24
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-1,600,805.24</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-7,590,217.77</b>	<b>-9,057,057.30</b>

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>370,911,000.0</b>	<b>419,077,560.00</b>
		<b>0</b>	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>32,885,000.00</b>	<b>14,114,960.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	32,885,000.00	14,114,960.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	32,885,000.00	11,360,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,125,000.00	11,360,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,760,000.00	00.00
120009	Бусад орлого	00.00	2,754,960.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>338,026,000.0</b>	<b>404,962,600.00</b>
		<b>0</b>	
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	338,026,000.0	402,775,100.00
		<b>0</b>	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	338,026,000.0	402,775,100.00
		<b>0</b>	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	2,187,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,187,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>370,911,000.0</b>	<b>409,167,460.00</b>
		<b>0</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>370,911,000.0</b>	<b>409,167,460.00</b>
		<b>0</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>342,795,845.9</b>	<b>382,338,840.64</b>
		<b>0</b>	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	134,432,487.0	143,630,419.00
		<b>0</b>	
210101	Үндсэн цалин	128,059,308.0	130,838,528.00
		<b>0</b>	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,373,179.00	12,791,891.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14,808,065.00	17,822,727.64
210201	Тэтгэврийн даатгал	8,428,588.00	11,326,120.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,937,266.00	1,501,593.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,336,046.00	1,179,858.00
210204	Ажилгүйдлийн даатгал	439,171.00	306,759.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,666,994.00	3,508,397.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,455,032.00	4,610,176.00
210301	Гэрэл, цахилгаан	577,764.00	716,716.00
210302	Түлш, халаалт	3,460,684.00	3,240,466.00
210303	Цэвэр, бохир ус	416,584.00	652,994.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,942,483.90	10,013,890.00
210401	Бичиг хэрэг	430,000.20	1,208,740.00
210402	Тээвэр, шатахуун	6,555,500.00	6,951,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,512,353.70	1,414,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	126,000.00	126,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	318,630.00	313,250.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	492,620.00	484,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	492,620.00	484,500.00

Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,432,160.00	4,463,160.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	419,460.00	417,560.00
210602	Тавилга	7,359,800.00	00.00
210604	Урсгал засвар	1,652,900.00	4,045,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,482,100.00	1,478,500.00
210702	Дотоод албан томилолт	1,482,100.00	1,478,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	52,463,056.00	36,420,560.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,975,000.00	34,898,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	178,000.00	178,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	325,950.00	337,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	138,530.00	140,610.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	800,576.00	800,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	116,287,842.00	163,414,908.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	115,551,342.00	163,114,908.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	736,500.00	300,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,115,154.10</b>	<b>26,828,619.36</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,800,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,800,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	23,315,154.10	26,828,619.36
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,315,154.10	26,828,619.36
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>9,910,100.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>7,403,140.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>7,403,140.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	7,403,140.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	7,403,140.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-7,403,140.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	2,506,960.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	2,506,960.00

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	117,277,647.48	596,063.99	-7,150,844.56	110,722,866.91
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	299,767.32	299,767.32
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>117,277,647.48</b>	<b>596,063.99</b>	<b>-6,851,077.24</b>	111,022,634.23
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-299,767.32	00.00	-299,767.32
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-43,610,921.97	-43,610,921.97
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>117,277,647.48</b>	<b>296,296.67</b>	<b>-52,241,152.47</b>	65,332,791.68
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>117,277,647.48</b>	<b>296,296.67</b>	<b>-52,241,152.47</b>	65,332,791.68
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	3,966,352.75	00.00	3,966,352.75
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	90,848,000.00	00.00	-9,057,057.30	81,790,942.70
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>208,125,647.48</b>	<b>4,262,649.42</b>	<b>-61,298,209.77</b>	151,090,087.13

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	413,935,100.0 0	389,741,980.0 4
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	413,935,100.0 0	389,741,980.6 4
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	413,935,100.0 0	389,741,980.6 4
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	166,625,500.0 0	143,630,419.0 0
210101	Үндсэн цалин	152,369,500.0 0	130,838,528.0 0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,256,000.00	12,791,891.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,995,100.00	17,822,727.64
210201	Тэтгэврийн даатгал	13,330,000.00	11,326,120.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,666,300.00	1,501,593.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,333,000.00	1,179,858.00
210204	Ажилгүйдлийн даатгал	333,300.00	306,759.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,332,500.00	3,508,397.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,669,900.00	4,610,176.00
210301	Гэрэл, цахилгаан	775,900.00	716,716.00
210302	Түлш, халаалт	3,240,600.00	3,240,466.00
210303	Цэвэр, бохир ус	653,400.00	652,994.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,024,500.00	10,013,890.00
210401	Бичиг хэрэг	1,209,500.00	1,208,740.00
210402	Тээвэр, шатахуун	6,951,600.00	6,951,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,414,100.00	1,414,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	126,200.00	126,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	323,100.00	313,250.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	495,000.00	484,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	495,000.00	484,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,516,300.00	8,516,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,470,700.00	4,470,700.00
210604	Урсгал засвар	4,045,600.00	4,045,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,482,100.00	1,478,500.00
210702	Дотоод албан томилолт	1,482,100.00	1,478,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	36,226,700.00	36,420,560.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,650,000.00	34,898,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	178,200.00	178,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,200.00	337,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,400.00	140,610.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	801,900.00	800,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	165,900,000.00	166,764,908.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	165,600,000.0 0	166,464,908.0 0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	300,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	413,935,100.0 0	416,322,600.0 0
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	402,775,100.0	402,775,100.0

Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

		0	0
131001	Улсын төсвөөс санхүүжих	402,775,100.0	402,775,100.0
		0	0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	11,160,000.00	11,360,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,160,000.00	11,360,000.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,187,500.00
1200042	ЗГНХ,Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,187,500.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		2,506,960.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	1,020.00	58,301.00
620001	Удирдах ажилтан	555.00	7,878.00
620002	Гүйцэтгэх ажилтан	455.00	4,545.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	45,878.00